

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 04 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлага болон хариуцлагатай байх зарчмуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, Засгийн газрын боловсруулсан төсвийн төсөлд олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт, төрийн аудитын ажиллах механизмыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзэж хууль, тогтоолын төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа боловч энэ удаагийн төсвийн шинэчлэлийг “Үндэсний хөтөлбөр” болгож хүрээг нь өргөжүүлэх замаар төсвийн суурь шинэчлэл болгох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин төсвийн шинэчлэлийн хүрээнд бусад салбарын хуулиудын уялдаа, холбоо, гарах үр дагаврыг тооцсон эсэх, Засгийн газраас хуулийн төсөлд өгсөн саналын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан төсвийн шинэчлэлийг Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан дахин боловсруулах ажлын хэсэг байгуулан Засгийн газартай хамтран ажиллах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа бөгөөд төсвийн шинэчлэлийн “Үндэсний хөтөлбөр”-ийг яаралтай боловсруулж, өргөн мэдүүлэхийг Засгийн газарт чиглэл болгох, энэ хугацаанд өргөн мэдүүлсэн төсвийн шинэчлэлийн бодлогыг цаг алдалгүй хэлэлцэх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор төсвийн оновчгүй бодлого хэрэгжүүлж мөчлөг дагасан шинжтэй явж ирсэн нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт сөргөөр нөлөөлж байгааг анхаарах, мөн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналыг сайжруулах, зардлын өсөлтийг бүтээмжээр хэмждэг болох, төсвийн бодлогыг эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн цогц өөрчлөлт, шинэчлэлтийг хийх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.


Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН